НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024.01.02 № 11/16

танай ______ -ны № ______ -т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тухай" А/1532 дугаар захирамжийн дагуу Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, нийслэлийн орон нутгийн өмчит төсөвт болон аж ахуйн тооцоот байгууллагуудын 2023 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлын хэсэг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн ажиллах бөгөөд ажлын хэсгийн удирдамжийг хүргүүлж байна.

Хавсралт 6 хуудастай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА Х.ГАНТУЛГА

ТТБ ± 2105

1110200005

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 12 сарын 27 өдөр　　　　Дугаар А/1532　　　　Улаанбаатар хот

Байгууллагуудын үйл ажиллагааны
үр дүнг үнэлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа орон нутгийн өмчит төсөвт болон аж ахуйн тооцоот байгууллагуудын 2023 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар батлсугай.

2.Байгууллагуудын 2023 оны үйл ажиллагааны үр дүнг Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын 2, 3, 4, 5 дугаар хавсралтын дагуу үнэлсүгэй.

3.Байгууллагуудын 2023 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлыг 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн дотор зохион байгуулж, дүнг танилцуулахыг зохион байгуулах Ажлын хэсэг (Л.Хосбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ　　　　Х.НЯМБААТАР

1110206716

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
...12 дугаар... сарын .22.-ны өдрийн
......А/1532 дугаар... захирамжийн
хавсралт

# БАЙГУУЛЛАГУУДЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг.Зорилго, үндэслэл

1.1.Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа орон нутгийн өмчит төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2023 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлын зорилго нь бүх шатанд ажлын хариуцлага, сахилгыг өндөржүүлэх, санал санаачилгыг өрнүүлэх замаар амжилтыг бататгах, төрийн ажил үйлчилгээнд ахиц дэвшил гаргахад оршино.

1.2. Монгол  Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам “-ыг тус тус эрх зүйн үндэслэл болно.

Хоёр.Хугацаа:

2.1.Үнэлгээний ажлыг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн ажлын 15 хоногт гүйцэтгэнэ.

2.2.Үнэлгээ хийсэн ажлын дүнг 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн дотор зохион байгуулах ажлын хэсэгт танилцуулна.

Гурав.Хамрагдах байгууллага:

3.1.Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа орон нутгийн өмчит төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд;

Дөрөв. Зохион байгуулалт:

4.1.Үнэлгээний ажлыг зохион байгуулах ажлын хэсэг нь байгууллагуудын 2023 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн ажлын нэгдсэн дүнг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулна.

4.2.Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ хийхдээ Үнэлгээний багийн гишүүд багийн ахлагчийн баталсан ажил үүргийн хуваарийн дагуу бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллана.

4.3.Үнэлгээний баг нь байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн үнэлгээний ажлын нэгдсэн илтгэх хуудас үйлдэх бөгөөд илтгэх хуудаст үнэлгээний багийн ахлагч болон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан зохион байгуулах ажлын хэсэгт ажлаа тайлагнана.

4.4.Үнэлгээний бодит байдлыг тухайн ажлын хэсэг хариуцна. Үнэлгээ хийсэн тухай илтгэх хуудаст байгууллагуудаас тухайн жилд хийсэн ажлын үр дүн, алдаа дутагдал, анхаарах зүйлс, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудын талаар тусгаж, үнэлгээ хийгдсэн байгууллага тус бүрийн үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу хүснэгтэн мэдээллээр гаргаж, хавсаргана.

4.5.Үнэлгээний багийн гишүүнээр томилогдсон албан хаагчийг ажиллах боломжоор хангах үүргийг тухайн албан хаагчийн ажилладаг байгууллага, нэгжийн удирдлага хүлээнэ.

4.6.Байгууллагуудын 2023 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын 2, 3, 4, 5 дугаар хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

Тав.Зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн дарга: | Л.Хосбаяр | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга |
| Гишүүд: | Ү.Ганболд | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга |
| | Б.Энхжин | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| | Д.Амгалан | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| | Б.Солонго | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга |
| | Б.Гантулга | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалтын тасгийн дарга |
| Нарийн бичгийн дарга: | Х.Гантулга | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга |

Зургаа.Үнэлгээний багийн бүрэлдэхүүн:

6.1.Дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх Үнэлгээний багийн бүрэлдэхүүн:

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Ү.Ганболд | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга |
| Гишүүд: | Б.Эрдэнэтуяа | Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга |
| | Э.Оргилцогцлох | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн |

| | | |
|---|---|---|
| | Ц.Нямдэлгэр | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн |
| | Г.Гүррагчаа | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн |
| | Г.Үйтүмэн | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн |
| | Н.Бумцэнд | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн |
| | Б.Мөнхбаяр | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн |
| | Д.Нансалмаа | Нийслэлийн Дотоод аудитын газрын Аудит, хяналт шалгалтын хэлтсийн ахлах дотоод аудитор |
| | Р.Саранцэцэг | Нийслэлийн Архивын газрын Төлөвлөлт, мэргэжлийн удирдлагын хэлтсийн дарга |
| Нарийн бичгийн дарга: | О.Мандах | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн |

6.2.Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч Агентлагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх Үнэлгээний багийн бүрэлдэхүүн:

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Б.Солонго | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга |
| Гишүүд: | Б.Загарсүрэн | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын тасгийн дарга |
| | Б.Ууганбат | Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн дарга |
| | Ц.Баттулга | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн |
| | Б.Зулцэцэг | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн |
| | Э.Навчаа | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн |
| | Д.Оюунжаргал | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн |

| | | |
|---|---|---|
| | Г.Хулан | Нийслэлийн Дотоод аудитын газрын Аудит, хяналт шалгалтын хэлтсийн ахлах аудитор |
| | Ц.Дунгармаа | Нийслэлийн Архивын газрын Төлөвлөлт, мэргэжлийн удирдлагын хэлтсийн Улсын байцаагч |
| Нарийн бичгийн дарга: | Д.Дөлгөөн | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн |

6.3.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн харьяа нийслэлийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх Үнэлгээний багийн бүрэлдэхүүн:

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Х.Гантулга | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга |
| Гишүүд: | М.Солонго | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн |
| | Н.Хашцэцэг | Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| | В.Баттулга | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| | Ж.Сайханбаяр | Нийслэлийн Дотоод аудитын газрын Аудит, хяналт шалгалтын хэлтсийн ахлах дотоод аудитор |
| | Г.Загдцэсэм | Нийслэлийн Архивын газрын Төлөвлөлт, мэргэжлийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн |
| Нарийн бичгийн дарга: | А.Энх-Амгалан | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн |

6.4.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн харьяа аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх Үнэлгээний багийн бүрэлдэхүүн:

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Б.Энхжин | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| Гишүүд: | П.Туул | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн |
| | Ж.Мөнхбаяр | Захирагчийн ажлын албаны Хяналт, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн |

| | | |
|---|---|---|
| | С.Цолмон | Нийслэлийн Дотоод аудитын газрын Аудит, хяналт шалгалтын хэлтсийн ахлах дотоод аудитор |
| | М.Энхболд | Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн менежментийн хэлтсийн дарга |
| | М.Чулуунхүү | Нийслэлийн Архивын газрын Төлөвлөлт, мэргэжлийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Улсын байцаагч |
| Нарийн бичгийн дарга: | Х.Нямбаяр | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн |

-----oOo-----